

ГАРЧИГ

2–4	Бодлогын нийтлэл
5–7	Зохицуулалтын мэдээ
8–10	Байр суурь
11	Тайлбар зөвлөмж
12–13	Тогтвортой санхүүжилт
14–15	Компанийн засаглал, комплайнс
16–17	Финтек ба регтек
18–25	Судлаачийн индэр
26–27	Олон улсын зах зээлийн мэдээ
28	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

МОНГОЛ УЛСАД ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТ ИННОВАЦ ХАБ БАЙГУУЛАХ СУУРЬ СУДАЛГАА

УДИРТГАЛ



Сүүлийн жилүүдэд санхүүгийн технологи буюу финтекийн хөгжил хурдсан уламжлалт банк, санхүүгийн салбарт урьд өмнө нь хүлээгдэж байгаагүй амар хялбар байдал, үр ашиг, хүртээмжийг авчирч байна. Гэсэн хэдий ч санхүүгийн салбарт өрнөж буй энэхүү хурдтай өөрчлөлтийг даган санхүүгийн зах зээлд шинэ

төрлийн эрсдэлүүд үүсэх, санхүүгийн салбарын интеграцчлалыг хурдасган санхүүгийн систем, тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг эрсдэлүүд ажиглагдаж байна. Иймд санхүүгийн зах зээлд шинээр үүсэж буй эрсдэлээс системийн тогтвортой байдал, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахын сацуу технологийн дэвшлийн зах зээлд авчирч буй үр шим, өгөөжийг боломжит түвшинд нь ашиглах чиглэлд улс орнуудын засгийн газар, бодлого гаргагчид, олон улсын байгууллагууд эрчимтэй ажиллаж байна.

Финтекийн энэхүү хөгжил Монгол Улсын зах зээлд ч мөн эрчимтэй нэвтэрч буй бөгөөд төрийн бодлого гаргагчид болон санхүүгийн зохицуулагч байгууллагууд технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлтийг дэмжин, тогтвортой хөгжилд хүрэх боломжийг эрэлхийлж байна.

Санхүүгийн салбар дахь инновацыг нэмэгдүүлэх, түүний үр шимийг хүртэх олон боломж, хурдасгуур хэрэгслүүдийн нэг нь Финтекийн инновацын хаб юм. Финтекийн инновацын хаб нь санхүүгийн салбарын оролцогчид, гарааны бизнесүүд, технологийн компаниудын хөгжлийг дэмжих, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүгийн салбарын экосистемийг хамарсан төв бөгөөд санхүүгийн байгууллагууд, технологийн компаниуд, хөрөнгө оруулагчид, академик салбарынхан, болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны цэг болон финтек салбарын хөгжил, инновацыг дэмжих чиглэлд ажилладаг.

Энэхүү судалгаа нь Монгол Улсад финтекийн салбарыг дэмжсэн инновацын хаб байгуулахын ач холбогдлыг судлах, олон улсын сайн туршлагаас судлан өөрийн орны нөхцөл байдалд нийцсэн инновацын хабын үйл ажиллагааны гол зураглал, холбогдох тооцооллыг гаргах мөн цаашид уг төлөвлөгөөг ажил хэрэг болгоход шаардлагатай ерөнхий төлөвлөгөөг гаргахад чиглэсэн. Судалгааны дараах бүлгүүдэд Монгол Улсын финтек салбарын өнөөгийн нөхцөл байдал, олон улсын чиг хандлага, инновацын хабын олон улсын туршлага, Монгол Улсын санхүүгийн зах зээлд инновацын хаб байгуулах хэрэгцээ, шаардлагыг судлан, инновацын хабын үндсэн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зураглалыг эхний байдлаар боловсруулан, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг гарган тусгасан болно.

Үргэлжлэл 18–р нүүрт



**ТАНЫ
САНХҮҮГИЙН
МЭДЛЭГТ**

САНХҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

Эх үүсвэрийг захиран зарцуулах эрх бүхий этгээд, засгийн газрын байгууллага, эсвэл нийтийн итгэлийн албан тушаалтан тухайн байгууллагын эх үүсвэрийг зарцуулах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар тайлагнах үүрэг



FINANCIAL ACCOUNTABILITY

Financial accountability is the obligation of anyone handling resources, public office or any other position of trust, to report on the intended and actual use of the resources or of the designated office.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

**ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ
ХАРЬЦААГ ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛААР
ТООЦДОГ БОЛНО**

Даатгагчийн төлбөрийн чадварын тооцооллыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн сайжруулж, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох зорилгоор тогтмол хувь, хязгаарлалт, дүрэмд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлал руу шилжүүлэх зохицуулалтыг тусгасан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталлаа.

Дэлхийн эдийн засгийн хямралуудыг авч үзвэл зохицуулагч байгууллагууд нь даатгагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлээс гадна системийн эрсдэлийг анхаарч үзсэн байдаг хэдий ч уламжлалт хяналт, шалгалтын арга хэрэгсэл нь

зохицуулалтад байдаг байгууллагуудад учирч болох санхүүгийн хүндрэлээс сэргийлэхүйц түвшинд эрсдэлийг үнэлж, удирдах хангалттай арга хэрэгсэл байж чадахгүй байсныг харж болно. Өөрөөр хэлбэл, хяналт шалгалтын уламжлалт арга хэрэгсэл нь даатгагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлж, тухайн даатгагчийн санхүүгийн чадвар болон бусад чадавхад хэрхэн нөлөөлөх талаар тооцоолж, харуулж чаддаггүй. Цаашилбал, энэ уламжлалт хандлага нь даатгагчийн үйл ажиллагаанд ноцтой хохирол учруулахааргүй материаллаг бус зүйлсэд анхаарал хандуулж, цаг их зарцуулдаг, мөн даатгагчийн санхүүгийн чадавх, үйл ажиллагааны хүрээнд хүндрэл учруулж болзошгүй, эрсдэл өндөртэй үйл ажиллагааг орхигдуулж,



улмаар хожуу мэдсэн тохиолдолд хариу арга хэмжээ авахад хүндрэл үүсгэдэг байна. Тэгвэл, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын гол зорилго нь даатгагчийн үйл ажиллагаанд эрсдэл учирсных нь дараа бус эрсдэл учрахаас нь өмнө олж мэдэж, урьдчилан сэргийлэх боломж олгодоггоороо давуу юм.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо нь 3 тулгуур багана бүлэг үзүүлэлтийг багтаадаг. Үүнд:

1. Тоон үзүүлэлтийн шаардлага

- Даатгалын нөөц сангууд
- Даатгагчийн төлбөрийн чадвар
- Шалгуур үзүүлэлт

2. Хяналт шалгалт

- Эрсдэлийн удирдлага ба засаглал
- Даатгагчийн өөрийн эрсдэл
- Төлбөрийн чадварын үнэлгээ
- Зохицуулагчийн хяналт шалгалт

3. Мэдээллийн ил тод байдал

- Санхүүгийн тайлан, нөхцөл, байдал
- Ил тод байдал
- Зах зээлийн ёс зүй, сахилга бат

Улс орнууд даатгалын зах зээл дээр эрсдэлд суурилсан хөрөнгийн тогтолцоог нэвтрүүлэх замаар даатгагчийг үйл ажиллагааг тогтвортой явуулах, даатгалын нөхөн төлбөр төлөх, цар тахал, эдийн засгийн хямрал гэх мэт цочролуудыг даван туулах хангалттай хэмжээний хөрөнгөтэй, санхүү хөрөнгө оруулалтын зөв бүтэц, зохион байгуулалттай байлгахыг зорьж байгаа бөгөөд дээрх тогтолцооны хүрээнд Эрсдэлд суурилсан хөрөнгө /Risk based capital/, Төлбөрийн чадвар–2 /Solvency-II/ гэсэн үндсэн 2 аргачлалыг өөр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байна.

Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа, шалгуур үзүүлэлтийг үндсэн 4–6 эрсдэлийн хүрээнд тодорхойлж, хөрөнгийг чанарын хувьд ангилан, зарим тохиолдолд даатгагч өөрийн эрсдэлийг илүү нарийвчилсан аргаар тооцоолох боломжийг олгож, даатгагчийн хөрөнгө, эрсдэлийн хэмжээнээс хамаарч өөр өөр эрсдэлийн түвшинг тогтоож өгдөг. Төлбөрийн чадвар–2 аргачлал нь даатгагчийн төлбөрийн чадварыг тоон шалгуур үзүүлэлтүүдээс гадна даатгагчийн өөрийн засаглал, эрсдэлийн удирдлага, тэдгээрт тавих хяналт, тайлагнал, ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан цогц системийн хүрээнд авч үздэг.

Даатгалын зохицуулагч байгууллагуудын олон улсын холбоо /IAIS/–ноос баталсан Даатгалын тулгуур 25 зарчим /ICP/–ын 17 “Хөрөнгийн хүрэлцээтэй байдал” –ын зарчимд зохицуулагч байгууллага нь даатгагчийг төлбөрийн чадвартай байлгах зорилгоор даатгагчийн хөрөнгийн хүрэлцээтэй байдалд шаардлага тавих, даатгагчид учирч болох эрсдэл нь хэрхэн нөлөөлөхийг тодорхой тусгах, хөрөнгийн элементүүдийн чанар, тохиромжтой байдлыг харгалзан шаардлагад нийцсэн хөрөнгө, тэдгээрийн үнэ цэнийг тооцох арга барилыг тодорхойлох, 16 “Байгууллагын эрсдэлийн удирдлага ба төлбөрийн чадвар” зарчимд зохицуулагч байгууллага нь даатгагчийг өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээг (ORSA) тогтмол хийж, эрсдэлийн удирдлагын хангалттай байдалд, одоогийн болон ойрын ирээдүйн төлбөрийн чадварын байдалд үнэлэлт хийхийг шаарддаг талаар тусгасан байдаг.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос эрсдэлд суурилсан хөрөнгийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр 2016 оноос хойш тогтмол арга хэмжээ авч хэрэгжүүлсээр ирсэн. Энэ хүрээнд өнгөрөгч он буюу 2022 онд даатгагчийн төлбөрийн чадварын тогтмол хувь, хязгаарлалт, дүрэмд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлалд шилжих шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”–ыг баталж, 2022 оны 3 дугаар улирлаас эхлэн зэрэгцүүлэн хэрэгжүүлсэн.


Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, олон улсын стандарт, чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдал, дээрх журам зааврын хэрэгжилтийн үр дүн, даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдоос ирүүлсэн санал зөвлөмж, тэдгээрт хийсэн судалгаа шинжилгээнд тулгуурлан даатгагчийн төлбөрийн чадварыг эрсдэлд суурилсан аргачлалаар тодорхойлох, эрсдэлийн үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох зорилгоор Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”–ын шинэчилсэн найруулгыг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08–ны өдрийн 559 дүгээр тогтоолоор баталлаа.

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” нь 4 бүлэг, 24 хавсралтаас бүрдсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхлэх юм.

Уг журмын дагуу эрсдэлийн түвшнийг зах зээлийн, зээлийн, андеррайтингийн болон үйл ажиллагааны зэрэг эрсдэл тус бүрийн хувьд тооцоолох боломжийг бүрдүүлсэн бөгөөд даатгагчийн үйл ажиллагааны цар хүрээ, эрсдэлийн шинж чанарт тохирсон шалгуураар тэдгээрийн төлбөрийн чадварыг үнэлэх, хөрөнгийн хүрэлцээт байдлын байвал зохих доод харьцааг даатгагчийн өөрийн эрсдэлийн түвшинтэй уялдуулан зохицуулалтуудыг тусгасан онцлогтой.

Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тодорхойлохдоо даатгагчийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа болон даатгагчийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүдийг ашиглах буюу даатгагчийн тоон болон чанарын үзүүлэлтийг ашиглан даатгагчийн төлбөрийн чадварыг сайн, хангалттай, эргэлзээтэй, төлбөрийн чадваргүй болж болзошгүй болон даатгагч төлбөрийн чадваргүй

гэсэн 5 түвшинд хувааж авч үзэн, түвшин бүрт тохирсон хяналт шалгалтын үйл ажиллагааг тодорхой болголоо.



ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ХҮСНЭГТ

Даатгагч нь байгууллагын бүтэц, бизнесийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, бүтээгдэхүүн үйлчилгээний багц зэргээсээ хамааруулан учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлох, хэмжих, зохистойгоор удирдах, хянах, тайлагнах аргачлалыг өөрт тохирсон байдлаар хэрэгжүүлэх боломж олгох зорилгоор “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” –ын хавсралтаар “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар” –ыг баталсан.

Дээрх журам, заавар хэрэгжиж эхэлснээр даатгагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо боловсронгуй, нээлттэй, ил тод болохын зэрэгцээ даатгалын зах зээлийн эрсдэлийг урьдчилан таних, түүнээс сэргийлэх систем нэвтрэх, улмаар салбарын засаглал сайжирч, тогтвортой байдал хангагдах, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын даатгалд итгэх итгэл нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

X (%) \ Y (%)	$X < (\min X - 20)$	$(\min X - 20) \leq X < (\min X - 10)$	$(\min X - 10) \leq X < \min X$	$X \geq \min X$	
$0 \leq Y < 10$	V	III	II	I	→
$10 \leq Y < 20$	V	IV	III	II	→
$20 \leq Y < 40$	V	V	IV	III	→
$Y \geq 40$	V	V	V	IV	→
	→	→	→	→	→
	Тоо хэмжээ				→

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН БЛОКЧЭЙН АРИЛЖААНЫ СИСТЕМИЙГ СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНД ТУРШИХААР БОЛЛОО



Сэндбоксын зөвлөлийнтавдугаар хуралдаан энэ сарын 07-ны өдөр боллоо. Энэ удаагийн хуралдаанаар “Сэндбокс орчны тойм, сэндбоксын албаны үйл ажиллагаа”, “Финтек зохицуулалтын инновац хаб байгуулах суурь судалгаа” болон сэндбоксын орчинд шинээр турших гурван бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг нийт таван асуудал хэлэлцлээ.

Хуралдааны үр дүнд “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ын хөгжүүлж буй биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем болон “Фандиа” ХХК-ийн урамшуулал, хандив, хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд нэг жилийн хугацаатай туршихаар боллоо. Биржийн бус зах зээлийн арилжаанд блокчэйн системийг нэвтрүүлснээр үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог автоматаар, цагийн хязгаарлалтгүй 24/7 гүйцэтгэх боломж бүрдэх юм. Түүнчлэн платформд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд шинэ төрлийн үйлчилгээ бөгөөд сэндбоксын орчинд туршигдаж буй хоёр дахь хамтын санхүүжилтийн үйлчилгээ юм.

Сэндбокс зохицуулалтын орчин нь технологийн дэвшилд суурилсан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хязгаарлагдмал орчинд турших, амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, онцлогт тохирсон зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиглэлд зах зээлийн оролцогчид, бодлого гаргагчид хамтран ажиллах боломжийг олгодог зохицуулалтын

арга хэрэгсэлбөгөөд манай улсын санхүүгийн зах зээлд нэвтрэн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг туршиж байна.

“КОМПЛАЕНСЫН ЭРСДЭЛИЙГ УДИРДАХУЙ” НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хороо Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо хамтран үнэт цаасны салбарт Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ФАТФ-ын зөвлөмж, стандартыг үр дүнтэй биелүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, нэгдсэн ойлголтод хүрэх зорилгоор “Комплаенсын эрсдэлийг удирдахуй” нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ “Өнөөдрийн байдлаар хөрөнгийн зах зээл тэр дундаа үнэт цаасны салбарт 608 зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаагаа явуулж байна. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгох, санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлд бид бодлогын хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байгааг Та бүхэн мэднэ. Энэ бүхний үр дүнд нь хувьцаат компаниудын



засаглалын чанарыг сайжруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаандаа хангах, үнэ цэнийг нь нэмэгдүүлэх зорилготой. Үүний тулд санхүүгийн зах зээлд оролцогчид болон иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал чухал тул энэ хүрээнд өнөөдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулж байна” гэдгийг онцолсон юм.

Хэлэлцүүлэгт үнэт цаасны зах зээлд оролцогчдын 80 гаруй төлөөлөл оролцож үнэт цаасны зах зээл дэх комплаенсын эрсдэлийг хэрхэн тодорхойлох, хөрөнгө оруулалтын менежментийн компани болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа ба комплаенсын эрсдэлийн талаар хэлэлцүүлэг өрнүүллээ. Мөн харилцагчийг таньж мэдэх ажиллагаа ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцсэний зэрэгцээ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан зохицуулалтын болон хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, үнэт цаасны салбарын хууль эрхзүйн орчин, цаашид хийх арга хэмжээний талаар мэдээлэл, санал солилцлоо.

ТЕКСПРИНТ УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА



Санхүүгийн зохицуулах хороо, Unread Media-тай хамтран санхүү, технологийн салбарын мэргэжилтнүүд, залууст зориулан анх удаа текспринт уралдааныг зохион байгуулахад бэлэн боллоо. Энэхүү уралдаан нь санхүүгийн салбар дахь инновацыг дэмжих, олон нийтэд технологид суурилсан санхүүгийн зах зээл болон сэндбокс зохицуулалтын үйл ажиллагааг таниулах, санхүүгийн зах зээл дэх тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, цахим технологид суурилсан ухаалаг, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд технологийн дэвшлийг ухаалгаар ашиглах шинэ санаа, инновац шийдлийг тодруулах зорилготой. Уралдаанд оролцогчид программ хөгжүүлэгч, график дизайнер, бизнес хөгжүүлэгч, судлаач, дата аналит, байгаль орчин, технологийн



салбарын мэргэжилтэн, оюутнууд, сонирхогчид байж болох бөгөөд уралдаанд оролцоход нас, туршлага харгалзахгүй оролцох боломжтой.



Уралдааны бүртгэл: 11 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл

Шалгаруулалт: Текспринт уралдаанд өрсөлдөх 10 багийг 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд оролцогчдын ирүүлсэн материалд үндэслэн сонгон шалгаруулна.

ОРОН НУТГИЙН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хороо орон нутгийн төлөөлөгчдөдөө зориулсан сургалтыг зохион байгууллаа. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан сургалтыг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн салбар, хадгаламж зээлийн хоршоо гэсэн дөрвөн салбарыг анх хариуцаж байсан бол холбогдох хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан эрх зүйн орчинтой холбоотойгоор хэд хэдэн чиг үүрэг нэмэгдсэнээр нийт 11 салбарын 6000 гаруй зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавьж ажиллаж байна. Энэ хугацаанд бид санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нэр төрлийг нь олшруулах, холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангуулах хүрээнд нэлээдгүй ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд нэлээдгүй өөрчлөлт, ахиц дэвшил гарлаа. 2011, 2012 онд зах зээлийн үнэлгээ

3 орчим их наяд төгрөг байсан бол 10 их наяд гаруй төгрөгт хүрч, зах зээл дээр 70 гаруй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрээд байна. Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаандаа хангах, санхүүгийн зах зээлийг ийнхүү хөгжүүлэхэд орон нутаг дахь зохицуулалтын байгууллагууд, иргэд олон нийтэд гүүр нь болж өгдөг төлөөлөгчид та бүхний оролцоо өндөр байсан” гэдгийг онцлоод нийт хамт олныхоо өмнөөс талархал илэрхийллээ. Мөн тэрбээр олон улсын байгууллагууд манай улсын санхүүгийн зохицуулалтын үйл ажиллагаанаас төвлөрөл буюу нэгдсэн дата мэдээлэлтэй байхыг шаарддаг. Өндөр хөгжилтэй орнуудад дата мэдээллийн нэгдсэн төвийг нь хяналт зохицуулалтын байгууллага буюу манайхтай чиг үүрэг ижил байгууллага хариуцдаг. Иймд энэ чиглэлд хүрэх зорилго тавин ажиллаж байгаа тул төлөөлөгчдөө чадавхжуулах шаардлага тулгарч байгаа гэдгийг онцолсон юм.

Сургалтад нийслэл болон орон нутгийн нийт 60 гаруй төлөөлөгч оролцож Хорооны үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, санхүүгийн зах зээлийн чиг хандлага, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл авч, санал солилцлоо. Мөн мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулалт болон сэдбокс орчны танилцуулга, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хууль эрхзүйн орчин, зах зээлийн нөхцөл байдал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбаруудын талаар мэдээлэл өгч хэлэлцүүлэг хийсэн юм.



БАЙР СУУРЬ

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО НЬ ASIAN SECURITIES FORUM-ЫН XXX ДАХ ЧУУЛГА УУЛЗАЛТЫГ 2025 ОНД МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛНА

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Ц.Наран-Учрал



Сайн байна уу? Үнэт цаасны зах зээлд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ярилцлагаа эхлүүлье.

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь эрхэм зорилгынхоо хүрээнд олон талт үйл ажиллагааг сайжруулах цогц арга хэмжээнүүдийг идэвхтэй хэрэгжүүлж байна. Бидний тэргүүлэх зорилгын нэг болох гадаад хамтын ажиллагааг дахин сэргээж, өргөжүүлэн, олон улсын хөрөнгө оруулагчдыг татах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, зах зээлийг төрөлжүүлэхэд таатай орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна. Олон улс дах мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагаагаа сайжруулж, тухайн улстай мэдээлэл солилцох, хамтарч ажиллах, арга хэмжээ зохион байгуулах, туршлага солилцох ажлын хүрээнд бид Япон улсын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (JSDA)-той хамтран ажиллах гэрээг хоёрдох удаагаа сэргээж зуран, мэргэжлийн оролцогчид, зохицуулагч байгууллагын хамтарсан арга хэмжээг Токио хотод зохион байгуулсан. Энэ хүрээнд Asian Securities Forum арга хэмжээг 2025 онд Монгол Улсад зохион байгуулахаар болсон. Энэ жил XXVIII дах чуулга уулзалт Энэтхэг улсын Мумбай хотод зохион байгуулагдаж Холбооны төлөөллүүд оролцсон.

Чуулга уулзалтад Азийн бүсийн 30 гаруй орны төлөөлөл ирж оролцдог. Энэ нь улс болгон дотоодын зах зээл дээр болж байгаа үйл явцыг танилцуулах, мэдээлэл солилцох, холбоод хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх өргөн хүрээний арга хэмжээ юм. Үүгээр дамжуулан Монгол улсаа сурталчлах, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, гадаад харилцааг нь нэмэгдүүлэх, боломжийг нэмэх зорилготой идэвхтэй ажиллаж байна.

Мөн сүүлийн жилүүдэд зөвхөн хөрөнгийн зах зээл гэхгүй нийт зах зээлд технологийн хөгжил асар хурдтай нэвтэрч орж ирж байна. Иймд Холбоо нь үнэт цаасны салбарт технологийн хөгжлийг нутагшуулах ажлыг идэвхтэй явуулж байгаа. Энэ яагаад бидний нэг ажиглах цэг болсон бэ гэхээр DLT технологи нь санхүүгийн салбарт ашиглагдаж болох сайн технологи гэдэг утгаараа сонирхлыг татаж энэ хүрээндээ биржийн бус зах зээлийн арилжаа болон арилжааны дараах үйл ажиллагааг DLT технологи ашиглах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны сэндрбоксийн орчинд бүртгүүлэн ажиллаж байна.

Монгол Улсад санхүүгийн зах зээл гэлтгүй зах зээлийн зарчимд шилжээд удаагүй байна. Үүнд санхүүгийн боловсрол, хөрөнгийн зах зээлийн ахисан шатны санхүүгийн үйлчилгээ бүтээгдэхүүнтэй холбоотой ойлголт өгөхийн тулд Холбооны зүгээс ч тэр, манай гишүүн байгууллагууд бүгд дэргэдээ анхан шатны сургалтыг зохион байгуулж, төрөл бүрийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран нийт ард иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатандаа тасралтгүй зохион байгуулж ажиллаж байна.

Зохицуулалттай этгээдүүдэд тулгамдаж буй чухал асуудлууд юу вэ? 5 жилийн өмнөхтэй харьцуулбал?

Сүүлийн 5 жилд манай зах зээл нь бүх талаараа сайжирсан гэдгийг оролцогч байгууллагууд хүлээн зөвшөөрнө гэж бодож

байна. Хоцрогдсон дүрэм журмууд шинэчлэгдэж, шинэ зохицуулалтууд гарч зохицуулалт хоорондын уялдаа холбоо сайжирсан. Тухайлбал биржийн бус зах зээл цоо шинэ харилцаа байсан, шууд хөрөнгийн зах зээлд хамаагүй боловч сэндрбоксын орчин үүссэн. Зохицуулалттай этгээдүүдийн хоорондын хамтын ажиллагаа сайжирч маш олон банк бус санхүүгийн байгууллагууд Хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргаж, нээлттэй болон хаалттай хэлбэрээр эх үүсвэр татаж байна. Энэ нь зөвшөөрлийн процесс хялбаршиж, шийдвэр гаргалт хурдан болсонтой холбоотой. Өнөөдөр хөрөнгийн зах зээл дээр олон төрлийн бүтээгдэхүүн олон төрлийн үйл ажиллагаа чөлөөтэй явагдаж байгаа нь зохицуулах орчин сайжирч байгаатай шууд холбоотой гэж харж байна. Ингээд төр болон холбоо хувийн хэвшил хамтраад үр дүнтэй ажиллах нь өөрөө санхүүгийн зах зээл тэр дундаа хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэхэд маш том ажил, баталгаа болж байна гэж харж байна. Цаашид үүсмэл үнэт цаас, бирж дээрх индекс дээр суурилсан сан, хөшүүрэгтэй арилжааны тухай, ОТС дээр хаалттай үнэт цаас арилжаалагдах гэх мэт нэг өдөр хийгдэхгүй боловч цаашид шинэ үүссэн журмын хүрээнд хийгдэх улам хөгжөөд явах бүтээгдэхүүнүүд байгаа гэж бодож байна. Мөн дурдахгүй өнгөрч болохгүй нэг зүйл нь мөнгөн хөрөнгийн номиналь дансны харилцаа үүсээд нэлээдгүй гишүүд төлбөр тооцооны шууд гишүүн болох номиналь дансаар харилцагчдаа үйлчилгээ үзүүлээд эхэлсэн. Энэ нь эргээд харилцагч нарт үйлчилгээ нь хялбарших төлбөр тооцоо хийхэд амархан болох гээд хөгжлийн нэг алхам болж байна. ҮЦТХТ дээр ахиц дэвшил гарсан нь өмнө цаасаар эх хувиар нь заавал аваачиж өгдөг байсан үйлчилгээнүүд цахимжсан. Энэ хүрээнд ҮЦТХТ-тай олон ажил үйлчилгээг хамтран хэрэгжүүлж байна. Бидэнд дэд бүтэц болон мэргэжлийнхний систем программын нэгдсэн бодлого стандарт дутагдаж байна. Юуг ч яаж ч сайжруулж болно, бид нар дундаа нэг стандарттай болж тогтчих юм бол стандартад нийцүүлээд аль аль талдаа системээ сайжруулалт хийхэд эргээд хоорондоо уялдаж ажиллах боломжтой болно. Энэ нь цаг мөнгө маш их хэмнэнэ бас үр дүнгүй давхардсан ажлуудыг болиулна, ерөнхийдөө систем сайжрах суурь маш чухал учраас энэ тал дээр холбоо бол нэгдсэн стандарттай бодлого баримтлах ёстой гэдэг үзлээр асуудалд хандаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих талаар мэргэжлийн оролцогчдын зүгээс юу хийж чадах вэ?

Холбоо нь Монгол Улсад орж ирэх гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн зорилтуудыг идэвхтэй

хэрэгжүүлж байна. Энэхүү хүчин чармайлтын гол зорилго нь аж ахуйн нэгжүүдэд Монголын зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай эх үүсвэрийг бий болгох, түүнчлэн зах зээлд бүтээгдэхүүн, төслийг санхүүжүүлэх, гадаадад ижил төстэй үйл ажиллагаа эхлүүлэх боломжийг олгох явдал юм. Гэсэн хэдий ч гадаад зах зээл рүү тэлэх нь тухайн улс орны зах зээлийн эрсдэл болон бусад асуудлууд зэрэг олон сорилтыг дагуулдаг. Холбооны гишүүн байгууллагууд зах зээлийг хамтдаа сурталчлах нь ганц компанийн хүчин чармайлтаас илүү ашигтай гэдгийг хамтдаа санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн. Энэ хамтын ажиллагааны арга нь шинэ зах зээлд гарахтай холбоотой эрсдэлийг бууруулах, хамтын нөөц бололцоог ашиглаж, туршлагаа хуваалцах явдал юм.

Холбооны зүгээс гаднын хөрөнгө оруулалтад нөлөөлөх сүүлийн үеийн хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг түгээх нь чухал юм. Эдгээр өөрчлөлтүүдийг идэвхтэй мэдээлэхгүй бол гадаадын хөрөнгө оруулагчид Монголын зах зээл дэх боломж, хөгжлийн талаар мэдэхгүй байх эрсдэлтэй. Холбооноос энэхүү зорилтынхоо хүрээнд Япон улсад Японы үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран нэг өдрийн арга хэмжээ зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээ нь Япон улсын холбооны гишүүн байгууллага, мэргэжлийн байгууллагуудад Монголын хөрөнгийн зах зээлийг сурталчлах, таниулах зорилготой. Тус арга хэмжээнд Монголын 10 гаруй аж ахуйн нэгжийн 20 гаруй төлөөлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагын түвшний хүмүүс оролцсон. Япон улсын 50 гаруй байгууллагын 70 гаруй төлөөлөгч оролцож, Монголын үнэт цаасны мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, шинэ бүтээгдэхүүн, боломжуудтай танилцлаа. Энэхүү хамтын ажиллагааны арга хэмжээ нь Японы оролцогч талуудын дунд Монголын зах зээлийн талаарх мэдлэг, сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал алхам болсон.

Холбооны гадаад хамтын ажиллагаа ямар түвшинд байгаа вэ? Цаашид аль бүс рүү илүү анхаарч байна вэ?

Мэргэжлийн холбооны хувьд Азийн зах зээлийн зарим улстай эрчимтэй харилцаа тогтоож эхлээд байна. Азийн зах зээл дээр хурдтай өсөж байгаа Хятад, Энэтхэг, Вьетнам, Тайланд, Солонгос, Хонконг, Сингапур, Япон гээд салбарын тэргүүлэх орнууд байна. Бид бүс нутагтаа эхний ээлжид цагийн нэг бүсэд байдаг хамтарч ажиллахад илүү ойр улсуудаасаа эхлээд хамтын ажиллагаагаа сайжруулахад анхаарлаа хандуулж байна. Мөн саяхан энэтхэг улсад болсон Asian securities forum-ын уулзалт дээр олон улсын ICSA холбоо манай Холбоог гишүүнээр элсэхийг урьсан. ICSA нь европ, хойд америкийн бүс нутгийн холбоод идэвхтэй оролцдог

том холбоо юм. Бусад орнуудын холбоодтой хамтарч ажиллах нь бусад орны зохицуулах байгууллагуудаас гарч байгаа шийдвэр, тэр нь гишүүн байгууллагууддаа яаж нөлөөлж байгаа талаар маш бүтээлч үр дүнтэй хурал, уулзалт семинаруудад байнга цахимаар оролцох боломжтой. Энэ нь бид цаг үеэсээ хоцрохгүй байх, туршлага хуримтлуулах, олон төрлийн шинэ асуудлыг олж харах, цаашдын хөгжилд үр өгөөжтэй байна.

Салбарын хүний нөөцийн нийлүүлэлт, чадамж ямар байгаа вэ?

Салбарын хүний нөөц сүүлийн жилүүдэд маш хурдацтай өсөж, мэргэжилтнүүдийн тоо нэмэгдэж байна. Үүнд бидний зүгээс үнэт цаасны салбарт ажиллах эрх олгох мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг. Сургалтад үнэт цаасны зах зээлд ажиллаж байгаа зохицуулах байгууллага, дэд бүтцийн байгууллага, мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүд мэргэшсэн чиглэлээрээ хичээл заадаг бөгөөд сургалтын багш нар заасан хичээлийнхээ хүрээнд өөрсдөө асуултаа боловсруулдаг. Цаашид мэргэжлийн академик сургалтын байгууллагатай хамтарч өөрийгөө бэлдэх гарын авлага, асуултын санг бий болгохоор ажиллаж байна. Энэ нь манай сургалтын үйл явцыг улам боловсронгуй болгож, шинэ боловсон хүчинд үнэт цаасны салбарт амжилттай ажиллахад чухал ач холбогдолтой.

Салбарын өрсөлдөх чадвар, хүртээмжийн талаар дүгнэвэл?

Хөрөнгийн зах зээлийн статистик бол эрс өссөн. 300 сая ам.доллар хүрэхгүй зах зээлийн үнэлгээтэй байсан манай зах зээл одоо 3 тэрбум ам.доллар орчимд хүрсэн байна. Энд мэдээж банкны реформ хамгийн өндөр хувь эзэлсэн буюу топ 5 банк үнэт цаас гаргаж хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдсэн нь зах зээлийн үнэлгээг эрс өсөхөд нөлөөллөө. Биржийн бус зах зээл дээр МХЗЗ-ийн 30 жилийн түүхэнд нээлттэй зах зээлд дээр өрийн хэрэгслээр босгосон дүн сүүлийн 2 жилийн хугацаанд ОТС буюу ББЗЗ дээр өрийн хэрэгслээр босгосон дүнг давж үнэт цаас гаргагч нарын тоо эрс өссөн. Манай Холбоо нь удахгүй Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, үнэт цаас гаргагчдын шилдгийг шалгаруулах салбарын дээд шагнал гардуулах ёслол болох "Grand Bull Awards" арга хэмжээг зохион байгуулах гэж байна. "Grand Bull Awards" шагнал гардуулах ёслолын арга хэмжээ нь анх 2013 онд тухайн үеийн Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллагуудын санаачилгаар

зохион байгуулагдсан бөгөөд өдгөө 5 жил тутамд зохион байгуулагддаг төрийн болон хувийн хэвшлийн компаниуд, зах зээлийн мэргэжлийн оролцогчдыг нэг дор цуглуулж шилдгүүдээ шалгаруулдаг уламжлал болсон арга хэмжээ юм. 2019 оноос 2023 он хүртэл цар тахалтай хүндхэн жилүүдэд өсөлттэй ажилласан цөөхөн салбарын нэг нь хөрөнгийн зах зээл юм. Сүүлийн 5 жилд Төрийн бодлого, зохицуулалтын хувьд маш чухал шийдвэр, шинэчлэлүүд хийгдэж үр дүнд зах зээлийн үнэлгээ 5 дахин, тус салбарын ажилтнуудын тоо 2–3 дахин нэмэгдэж, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.



ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АКТИВТ ТАВИХ ШААРДЛАГАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн активт тавьж байсан шаардлагыг хөнгөвчилж, активын бүрэлдэхүүнд оруулж болох боломжит активын хувь хэмжээг нэмэгдүүлэх буюу зарим хязгаарлалтуудыг бууруулах зэрэг холбогдох өөрчлөлтийг “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-д 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 464 дүгээр тогтоолоор оруулав.

Тухайлбал, уг журамд дараах онцлог өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

1. Хувьцааны сан буюу арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд хөрөнгө оруулах хамтын ХОС-ийн хувьд:
 - ◆ Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компани, түүнтэй холбогдох этгээдийн нийт гаргасан хувьцааны 30-аас дээшгүй хувийг эзэмшиж болох бөгөөд түүнд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулах;
2. Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сан буюу Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, нийтэд санал болгон гаргасан компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг тогтмол мөнгөн урсгал авах боломжтой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах хамтын ХОС-ийн хувьд:
 - ◆ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд оруулсан нийт хөрөнгө нь сангийн нийт активын 50 хувиас илүүгүй байх;
 - ◆ Нэг компанийн нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн 30-аас дээшгүй хувийг эзэмшиж болох бөгөөд түүнд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулах;

3. Тэнцвэржүүлсэн сан буюу хувьцааны болон тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн аль алинд нь хөрөнгө оруулах хамтын ХОС-ийн хувьд:

- ◆ Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй байх;
- ◆ Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компани, түүнтэй холбогдох этгээдийн хувьцаа, нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн 30-аас дээш хувийг эзэмшихгүй байх бөгөөд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулах;

4. Хамтын хөрөнгө оруулалтын сан нээлттэй хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан банкны системд нөлөө бүхий банкны хувьцаанд сангийн нийт активын 40 хүртэлх хувийг хөрөнгө оруулж болно.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭР

БАЙШИНГАА ДУЛААЛАХ УУ, НҮҮРС ТҮЛЭХ ҮҮ?

(Зориг сан, Konrad Adenauer Stiftung, 2018) судалгаанаас Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувь нь гэр хорооллын өрхүүдийн хатуу түлшний зуухны утаанаас, 10 хувь нь автотээврийн хэрэгслээс ялгарах хорт утаанаас, 6 хувь нь гурван том дулааны цахилгаан станцын жилийн нүүрсний хэрэглээнээс, 4 хувь нь хог шороо хөрсний бохирдлоос тус тус ялгарч байгаа үр дүн гарсан байна. Үр ашиг муутай халаалтын систем, орлогын хүрэлцээгүй байдал, байшингийн дулаан алдагдал зэрэг нь түлшний хэрэглээг нэмэгдүүлэх гол шалтгаан болж байна. Энэ нь эргээд агаар мандал, газрын хөрс, орчноо бохирдуулахын сацуу Нийслэлийн нийт иргэдийн эрүүл мэндийг ноцтойгоор хохироож байгаа юм.

Энэ удаагийн дугаараар танд нэг айл өрх амины орон сууцаа дулаалж, эрчим хүчний хэмнэлттэй халаагуур ашигласны

нөлөөгөөр хэдий хэмжээний зардал гарах болон нүүрсхүчлийн хийг бууруулж чадаж байгаа тооцооллыг танилцуулахаар бэлтгэлээ.

Амины орон сууцаа дулаалахтай холбоотой “Дулаан шийдэл” төсөл, youtube суваг зэргээр зөвлөгөө, мэдээллүүд хангалттай байдаг. Тэгвэл дулаалга хийхэд гарах өртөг, үр өгөөж дараах байдалтай байна.

Зардлаа тооцоходоо 50 кв амины орон сууцыг дулаалахад дээвэр, цонх, хана, шал, хаалгаа дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй чулуун хавтантай халаагуур худалдан авахад нийт зардал 8,980.9 мянган төгрөг болох бөгөөд нэг удаа дулаалгадаа ийнхүү хөрөнгө оруулалт хийснээр 13 жил ашиглагдах ба үүнийг өнөөгийн үнэ цэнээр тооцолгүйгээр бодоход жилд 690.8 мянган төгрөг ногдох юм.

Хүснэгт. Дулаалга, халаалтад зарцуулах зардал

Дулаалах объект	Дулаалгад шаардлагатай материал	Хэмжээ, тайлбар	Материалын үнэ	50 кв-т ногдох үнэ
Дээвэр	Ус чийг тусгаарлагч	70 кв	119,000.0	119,000.0
	Дээвэр	Базальт лайт – нягт 40, 10 см зузаан, 2.4 кв	48,544.0	1,011,333.3
Цонх /3 цонхтой/	Резин жийрэг	7.5	5,000.0	75,000.0
	Цонх /3 цонхтой/	1м*5м	35,000.0	70,000.0
	Цонх /3 цонхтой/	3	12,000.0	36,000.0
Хана	Чулуун хөвөн	Базальт лайт – нягт 40, 10 см зузаан, 2.4 кв	48,544.0	1,577,680.0
	Хана	70 кв	119,000.0	238,000.0
	Хана	4м	7,000.0	1,050,000.0
	Хана	20 кг (6–8 кв)	95,000.0	950,000.0
Шал	Хөрсний ус чийг тусгаарлагч	Плантер 2м*20м	276,000.0	227,000.0
	Шал	1 боодол – 5.5кв	109,000.0	990,909.1
	Шал	2	18,000.0	36,000.0
Хаалга	Бүргэд хаалга	40 градуст тэсвэртэй	1,600,000.0	1,600,000.0
Цахилгаан халаагуур	Чулуун хавтантай	2	500,000.0	1,000,000.0
Нийт зардал				8,980,922.4

Тайлбар: Амины орон сууцны таазны өндрийн стандарт хэмжээ 2.6 метрээр тооцов. Дулаалгын материалын үнийн мэдээллийг 100ail.mn болон Росторг компаниас авсан. Дээрх зардалд хадаас, скоч зэрэг жижиг зүйлсийн болон өөрсдөө дулаалга хийнэ гэж үзэн хөдөлмөрийн зардлыг оруулаагүй.






Дээрх зардлыг амины орон сууцаа дулаалаагүй, түлээ, нүүрс түлдэг байх хувилбартай харьцуулбал:



“Дулаан шийдэл” төслийн суурь судалгаагаар амины орон сууцаа дулаалаагүй өрхүүд жилд дунджаар 69 уут түлээ, 4 тонн нүүрс түлдэг гэж хариулсан байсан. Уг түлшний зардлыг дундаж зардлаар үржүүлэн тооцоход түлээнд 241.5 мянган төгрөг, нүүрсэнд 600.0 мянган төгрөг, өвлийн улиралд нэмэгдэж буй цахилгааны төлбөр 75.0 мянган төгрөг буюу нийтдээ хүйтний улиралд 916.5 мянган төгрөг зарцуулж байна. Үүнийг инфляцын нөлөөг оруулалгүй 13 жилээр тооцвол 11.9 сая төгрөг болох юм.

Зөрүү дүн жилд **225.7** мянган төгрөг, 13 жилд **2,933.6** мянган төгрөг болж байна.

Дулаалга хийгээд, хатуу түлш хэрэглэхгүй байснаар үүсэх үр өгөөж юу вэ?

-  Агаарын бохирдол буурч эрүүл мэндийн зардал буурна;
-  Бага насны хүүхдүүд эрүүл орчинд өсөж торнино;
-  Гэртээ тав тухтай амьдарна;
-  Гал түлэх, түлш бэлтгэх цаг хугацаа хэмнэгдэнэ;
-  Түлшний зардал буурч, хуримтлал нэмэгдэнэ.

Амины орон сууц дулаалахад нэг дор их хэмжээний зардал гарах ба энэхүү хөрөнгө оруулалтын зардлыг хаанаас босгох вэ гэдэг асуулт гарч ирнэ. Үүнд хэд хэдэн хувилбар байна. Нэгдүгээрт, хуримтлал үүсгэх. Хоёрдугаарт, жилийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй эсвэл жилийн 14–16 хувийн хүүтэй зээлээр дулаалгын материал, халаагуур худалдаж авах. Гуравдугаарт, сар бүрийн орлогоосоо хана, дээвэр зэргээ дараалан дулаалах.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн тайлагналын зөвлөлөөс компанийг үр дүнтэйгээр удирдан чиглүүлж, зорилгодоо хүрэхийн тулд төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн үйл ажиллагаа, ТУЗ-ийн дарга, гишүүд, түүний дэргэдэх хороодын үр нөлөө, чадварт жил бүр үнэлгээ хийхийг компаниудад үүрэг болгосон Нигерийн Компанийн засаглалын кодекс (NCCG)-ийг 2018 онд танилцуулсан байна.

Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагаа болон дарга, гишүүдийн үйл ажиллагааг үнэлэх замаар цаашид анхаарал хандуулах шаардлагатай асуудлыг тодорхойлж, компанийн засаглалын хэрэгжилтийг сайжруулах боломжтой.

ТУЗ-ийн үнэлгээ хийх ач холбогдол болон яагаад чухал болохыг дор дурдав.

ТУЗ-ийн гүйцэтгэлийг сайжруулах

Зорилгодоо хүрэхэд саад болж буй асуудлыг олж илрүүлдэг. Амжилтад хүрэхийн тулд аливаа байгууллага хүний нөөц болон бусад оролцогч талуудыг үр дүнтэйгээр удирдах хэрэгтэй бөгөөд ТУЗ-ийн үнэлгээг тогтмол хийснээр сайжруулах шаардлагатай талбар (харилцаа холбоо, шийдвэр гаргах үйл явц,


засаглалын үйл ажиллагаа гэх зэрэг)-ийг тодорхойлж, улмаар түүнд анхаарлаа хандуулснаар үр дүнтэй ажиллаж, байгууллагад ашигтай шийдвэр гаргах боломж бүрдэнэ.

Хариуцлагыг нэмэгдүүлэх

Байгууллага доторх хариуцлагын соёлыг төлөвшүүлдэг. ТУЗ-ийн гишүүд өөрсдийн хийсэн үйлдэл, шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээж хэвшвэл тэд илүү хариуцлагатай ажиллаж, байгууллагын зорилгод нийцсэн шийдвэр гаргах магадлал өсдөг. ТУЗ-ийн үнэлгээгээр дамжуулан ТУЗ-ийн гишүүд хувь хүний болон хамтын үүрэг хариуцлагын талаар илүү сайн ойлголттой болж, үр дагаврыг ухамсарладаг болсноор ил тод байдал, засаглалыг сайжруулах ач холбогдолтой. Эцсийн дүндээ ТУЗ-ийн үнэлгээнд хамрагдах нь бүх оролцогч талуудад ашигтай хариуцлагын соёлыг төлөвшүүлэхэд тусална.

Эрсдэлийн удирдлагыг сайжруулах

Эрсдэлийг бууруулж, удирдлагыг сайжруулдаг. ТУЗ-ийн гүйцэтгэлийг үнэлснээр эрсдэлийг тодорхойлж, түүнийг бууруулах,



хууль тогтоомжийн нийцлийг хангах зэрэг эрсдэлийн удирдлагын үйл явцыг сайжруулж, шаардлагатай асуудалдаа анхаарал хандуулж чадна. Эрсдэлийг тогтмол үнэлж, хэрэгжилтэд задлан шинжилгээ хийснээр болзошгүй тодорхойлж, тэдгээрийг багасгах арга хэмжээ (эрсдэлийг бууруулах стратеги боловсруулах, хэрэгжилтийг сайжруулах, байгууллагын эрсдэлийн удирдлага (ERM)-ын тогтолцоог хэрэгжүүлэх бодлого зэрэг)-г авах боломжтой болдог байна.

Хамтын ажиллагааг бэхжүүлэх

Байгууллага доторх харилцаанд эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд нээлттэй, шударга харилцаанд суурилсан бат бэх харилцааг хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Тогтмол үнэлгээ хийснээр ТУЗ-ийн гишүүд байр сууриа чөлөөтэй илэрхийлэх нөхцөл бүрддэг бол компанийн хувьд ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар ойлголттой болдог ач холбогдолтой. ТУЗ-ийн үнэлгээний үйл явцыг байгууллага доторх харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх боломж гэж үзэж болох бөгөөд ТУЗ багаар ажиллах, хамтын ажиллагаагаа сайжруулж, байгууллагад ашигтай шийдвэр гаргах, үр дүнтэй засаглалыг бий болгох боломжтой.

Шийдвэр гаргалтыг сайжруулах

Шийдвэр гаргахад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын өндөр түвшний мэдээлэл олон талт мэдлэг, туршлага шаардлагатай. Аливаа шийдвэр нь оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, байгууллагын урт хугацааны тогтвортой байдлыг хангах ёстой.

ТУЗ-ийн үнэлгээ нь ТУЗ болон түүний хороодын шийдвэр гаргалтын үр дүнтэй, цаг үеэ олсон байдал, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хамтын ажиллагаанд үнэлэлт өгдөг тул шийдвэр гаргагчдыг шаардлагатай мэдээллээр хангахаас гадна дараах асуудлыг тодорхойлоход тусална. Үүнд:

- ◆ ТУЗ-ийн гишүүдийн ур чадварыг хэрхэн үр дүнтэй ашиглах;
- ◆ ТУЗ-ийн компанид оруулах хувь нэмрийг сайжруулах арга зам;

- ◆ Болзошгүй эрсдэл;
- ◆ Стратеги боловсруулах хэрэгцээ;
- ◆ Бусад үнэ цэнтэй ойлголтууд.

Ил тод байдлыг хангах

Ил тод байдлыг хангах нь оролцогч талуудтай тогтвортой харилцааг тогтоох, итгэлцлийг бий болгох, байгууллагыг нэр хүндийн эрсдэлд хүргэж болзошгүй аливаа сөрөг үйл ажиллагаанаас хамгаалахад чухал ач холбогдолтой. ТУЗ-ийн үнэлгээг тогтмол хийснээр ТУЗ-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулж чаддаг төдийгүй ТУЗ-ийн гишүүдэд бие биетэйгээ ил тод байх, хариуцлагатай байх боломж олгодог.

ТУЗ-ийн бүрэлдэхүүний эрх тэгш байдлыг хангах

ТУЗ-ийн бүх гишүүдэд байгууллагын амжилтад хувь нэмрээ оруулах боломжийг олгох замаар ТУЗ-ийн тэгш байдлыг хангадаг.

ТУЗ-ийн үнэлгээ нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, мэдлэгийг тодорхойлох замаар тэдгээрт үүрэг хариуцлага, боломжуудыг тэгш хуваарилахад тусалж, өөрийн үзэл бодол, дуу хоолойгоо илэрхийлж, байгууллагын шийдвэр гаргах үйл явцад бодитой хувь нэмэр оруулахад дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн, ТУЗ-ийн олон талт байдал, тэгш оролцоонд (DEI) учирч болзошгүй аливаа гажуудал, саад тотгорыг илрүүлж, түүнийг шийдвэрлэн, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд тусалдаг.

ТУЗ-ийн даргын хувьд байгууллагын амжилт эсвэл бүтэлгүйтэл нь ТУЗ-ийн гүйцэтгэлээс хамаардаг гэдгийг ойлгох нь зүйтэй. Ингэснээр ТУЗ-ийн гишүүд дангаараа болон хамт олноороо үүргээ үр дүнтэй арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлнэ гэсэн үг. Тиймээс тухайн байгууллагыг зөв чиглүүлж, оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд ТУЗ-ийн гүйцэтгэлийг эрэмбэлэх нь шаардлагатай.

Дүгнэж хэлэхэд, ТУЗ-ийн үнэлгээнд оролцож буй холбогдох талууд энэхүү үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй оролцсоноор танай байгууллагад эерэг үр дүнг харах цорын ганц арга зам юм.

ФИНТЕК БА РЕГТЕК

“Wealthtech”-ийн ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА


Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ “Wealthtech” буюу хөрөнгийн удирдлагын технологийн талаар болон түүний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. “Wealthtech”-ийг тайлбарлахаас өмнө бид эхлээд хөрөнгийн удирдлагын ойлголтыг өгөх болно. Энэ нь санхүүгийн зөвлөхүүдээс чинээлэг үйлчлүүлэгчдэдээ санхүүгийн байдлаа шийдвэрлэх, сайжруулах зорилгоор үзүүлдэг хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ юм. Ийм үйлчилгээнд татварын төлөвлөлт, хөрөнгийн хамгаалалт, үл хөдлөх хөрөнгийн төлөвлөлт, өв залгамжлалын төлөвлөлт, гэр бүлийн засаглал, баялгийн бүтэц, төлөвлөлт зэрэг багтана. Зөвлөхүүдийн гол зорилго бол үйлчлүүлэгчдийн хөрөнгийг баялгаа өсгөх, хадгалах, хамгаалахад нь туслах явдал юм.

“Wealthtech” нь хөрөнгийн удирдлагын үйл явцыг хөнгөвчлөх зорилготой аливаа дижитал шийдлүүдийг хамардаг. Дижитал

төлбөр тооцоо (payments), зохицуулалтын технологи (regtech), даатгалын технологи (insurtech) болон бусад зүйлсийн зэрэгцээ “Wealthtech” нь финтекийн салбаруудын нэг юм.

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын 2023 оны 7 дугаар сарын тоймд нийтлэгдсэн дугаарт “Wealthtech”-ийн нийт санхүүжилт 2023 оны эхний хагаст 0.2 тэрбум ам.доллар байсан нь финтекийн салбар болон бусад дэлхийн зах зээлд тодорхойгүй байдлыг бий болгож буй хүчин зүйлсийн хүрээг харгалзан үзвэл гайхах зүйл биш юм. 2023 оны эхний хагаст 100 сая ам.долларын цорын ганц хэлцэл АНУ-д хийгдсэн бөгөөд энэ нь дэлхийн хэмжээнд “Wealthtech”-ийн зах зээлд тогтворжсон компани болох Avenue One –аас байв.

Зураг. Дэлхийн “Wealthtech” салбарын хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

“Wealthtech”-ийн 2023 оны эхний хагаст онцлох гол үйл явдлууд нь:

KYC болон CDD-д төвлөрсөн хиймэл оюун ухааны хэрэглээ

Финтек болон илүү өргөн хүрээний технологийн орон зайтай адил “Wealthtech”-ийн хөрөнгө оруулагчид 2023 оны эхний хагаст хиймэл оюун ухааныг идэвхжүүлэх, өвөрмөц шийдлүүдийг гаргахын тулд хиймэл оюун ухааныг ашиглах сонирхол нэмэгдэж байгааг харуулж байна. Хөрөнгийн удирдлагын талбарт энэхүү анхаарал голчлон харилцагчийн хяналт (CDD) болон харилцагчаа таних (KYC) шийдлүүдэд голчлон чиглэв. Хөрөнгийн менежментийн компаниуд хуурамчаар эерэг үр дүн гаргах, гар ажиллагаа, хөндлөнгийн оролцоог багасгахыг эрэлхийлж байгаа тул гүйлгээний хяналттай холбоотой шийдлүүд бас анхаарал татаж байна.


ASPAC бүс нутагт “Wealthtech”-ийн сонирхол нэмэгдэж байна.

ASPAC бүс нутгийн зах зээлийн харьцангуй бага хувийг эзэлдэг ч “Wealthtech” саналуудын сонирхол нэмэгдэж байна. Бүс нутгийн буурай хөгжилтэй орнуудын дундаж давхарга нэмэгдэж байгаа нь энгийн бэлэн мөнгөний данснаас гадуур банкны шинэ бүтээгдэхүүн, тэр дундаа санхүүжилтийн боломж бүхий шийдлүүдийн эрэлтийг нэмэгдүүлж эхэлсэн. Робо-зөвлөхүүд нь арилжаанд хялбар нэвтрэх, олон төрлийн санхүүжилт олгох боломжийг олгон өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдийн нөөцийг

хангахад улам бүр үүрэг гүйцэтгэж байна.

2023 оны сүүлийн хагас жилийн “Wealthtech” салбарын анхаарах чиг хандлага:

- ◆ Хөрөнгийн менежерүүдийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх робот зөвлөгөө robo-advisory чадавхжуулах. Хөрөнгийн удирдлагын хүрээг хамарсан үйлчлүүлэгчдэд зориулсан хувийн тохиргоог сайжруулах зорилгоор хиймэл хиймэл оюун ухааныг ашиглахад илүү анхаарч байна.
- ◆ Угсармал санхүү болон “Wealthtech”-ийн нэгдлийг нэмэгдүүлэх.
- ◆ Хөрөнгийн менежментийн зөвлөгөө, боломжуудыг цаашид хүртээмжтэй болгох зорилгоор бие даан суралцах платформын тоо өсөн нэмэгдэж байна



СУДЛААЧИЙН ИНДЭР

МОНГОЛ УЛСАД ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТ ИННОВАЦ ХАБ БАЙГУУЛАХ СУУРЬ СУДАЛГАА

Эхлэл нь 1-р нүүрт

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын Сэндбоксын албаны дарга Б.Батчимэг batchimeg_b@frc.mn

ФИНТЕКИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Финтекийн зах зээл

Монгол Улсын санхүүгийн зах зээл нь банкны салбарт суурилсан бүтэцтэй бөгөөд саяхныг хүртэл манай улсын санхүүгийн салбарын 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байсан бол сүүлийн жилүүдэд банкнаас бусад санхүүгийн салбарууд болох хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл болон бичил санхүүгийн салбар хурдацтайгаар өсөж хөгжин нийт санхүүгийн систем дэх банкны салбарын төвлөрөл саарч байна. Энэхүү өөрчлөлтөд технологийн дэвшлийн нөлөө чухал ач холбогдолтой. Технологийн дэвшлийн нөлөөгөөр хэрэглэгчид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг амар хялбар хүртэхээс гадна зах зээл дээр хэрэглэгчдийн санхүүжилтийн хэрэгцээ, шаардлагад тохирсон олон шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч байна.


Монгол Улсын санхүүгийн системд нийт 12 арилжааны банк тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд нэг арилжааны банк нь бүрэн цахим буюу нео банк хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол үлдсэн 11 арилжааны банкуудын хувьд интернэт болон мобайл банкаар дамжуулан хэрэглэгчдэд цахим үйлчилгээ үзүүлдэг болоод нэлээдгүй хугацааг үдэж байна.

Зураг. Монгол Улсын финтек зах зээлийн экосистем



Монгол Улсын тухайд иргэдийн бэлэн мөнгөний хэрэглээ жил ирэх тутам буурч буй бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар гэхэд нийт гүйлгээн дэх бэлэн мөнгөний гүйлгээний тоо 16 хувьтай байна. Энэхүү үзүүлэлт нь 2016 онд 45 хувьтай байсан бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй буурч буй юм (Монголбанк, 2022). Өнөөгийн байдлаар Монголбанкнаас цахим мөнгө, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрөлтэй нийт 7 компани зах зээлд цахим хэтэвч, төлбөрийн хэрэгслийн үйлчилгээг эрхэлж байна.

Зураг. Банк бус санхүүгийн байгууллагын финтек зээлийн статистик



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн салбарт технологийн дэвшлийг ашиглан P2P, хамтын санхүүжилт болон худалдан аваад дараа нь төл (buy now pay later) үйлчилгээнүүд шинээр нэвтэрч байна. P2P зээл болон хамтын санхүүжилтийн үйлчилгээнүүдийн хувьд сэндрбок зохицуулалтын орчинд хамрагдан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж байгаа бол худалдан аваад дараа нь төлөх нөхцөл бүхий үйлчилгээний хувьд санхүүгийн зохицуулалтад хамаарахгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөрөнгийн зах зээл, болон даатгалын зах зээлийн оролцогчид мөн өөрсдийн үйлчилгээг хэрэглэгчдэд цахимаар хүргэж эхэлсэн

Зураг. Виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Түүнчлэн финтекийн хөгжил хамгийн амжилттай нэвтэрч буй салбар нь банк бус санхүүгийн байгууллагын салбар тэр дундаа зээлийн үйлчилгээ бөгөөд нийт 42 банк бус санхүүгийн байгууллага гар утасны аппликэйшнд суурилсан финтек зээлийн үйлчилгээг эрхэлж байна.

2023 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын салбарын зээлдэгчдийн тоо 1.3 саяд хүрсэн бөгөөд үүний 93 хувийг финтек зээлдэгчид бүрдүүлж байна. Мөн салбарын нийт зээлийн үлдэгдэл 3.1 их наяд төгрөг хүрснээс 4.2 хувийг финтек зээлийн үлдэгдэл эзэлж байна. Салбарын хэмжээнд нийт олгосон зээлийн 19.2 хувийг, төлөгдсөн зээлийн 20.5 хувийг мөн тус тус финтек зээлийн үйлчилгээ бүрдүүлж буй юм.

бөгөөд 2023 оны 2 дугаар улирлын байдлаар хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг нийт 52 үнэт цаасны компаниас 18 нь цахим үйлчилгээг нэвтрүүлэн хөрөнгө оруулагчдад үнэт цаасны дансаа цахимаар нээх, мөн хөрөнгийн зах зээлийн арилжаанд гар утасны аппликэйшн болон цахим хуудсаа ашиглан шууд оролцох боломжийг бүрдүүлсэн байна. Даатгалын салбарын хувьд ердийн даатгалын нийт 16 компани байгаагаас 8 нь цахим үйлчилгээг нэвтрүүлэн иргэдэд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар борлуулж байна.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд тохиосон хамгийн том өөрчлөлтүүдийн нэг нь виртуал хөрөнгө болон криптовалютын зах зээл бөгөөд уг зах зээл Монгол Улсын санхүүгийн салбарт ч мөн хурдтайгаар нэвтрэн хөгжиж байна. Монгол Улсын хувьд виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгчид буюу биржүүдийг хянаж зохицуулдаг бөгөөд өнөөгийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй нийт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 263.9 тэрбум төгрөг байна.

Технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн системд шинээр нэвтэрч буй нэг үйлчилгээ нь цахим платформд суурилсан мөнгөний захын бирж юм. Тус биржээр банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцаар баталгаажсан репо хэлцэл, итгэлцэл болон хадгаламжийн сертификатад суурилсан мөнгөний захын хэрэгсэл арилжаалагдан сэндроксын орчинд туршигдаж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар уг платформоор дамжин нийт 705 удаагийн хэлцлээр 118.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчинд нэлээд түгж буй бодлогын хэрэгсэл нь технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн,

үйлчилгээ, инновацыг хязгаарлагдмал хүрээнд бодит орчинд турших боломжийг олгодог сэндроксын зохицуулалт бөгөөд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хувьд 2021 оны 3 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтарсан тушаалаар “Сэндрокс зохицуулалтын орчны журам”-ыг баталж, уг зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлсэн. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар сэндрокс зохицуулалтад өөрсдийн хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг турших нийт 15 хүсэлт ирсэн бөгөөд эдгээрээс 5 нь сэндроксын орчинд орон 1 үйлчилгээ нь нэг жилийн хугацаагаар туршигдан сэндроксын орчноос гарч, 4 үйлчилгээ нь туршигдаж байна.


ФИНТЕКИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ ОЛОН УЛСАД

Финтек салбарын зах зээл, хүлээгдэж буй ирээдүй

2022 оны байдлаар дэлхийн финтекийн зах зээлийн үнэлгээ 194.1 тэрбум ам.доллараар үнэлэгдэж буй бөгөөд 2030 он гэхэд тус зах зээл 936.5 тэрбум ам.доллар хүрч өсөх төлөвтэй байна. Саяхныг хүртэл финтекийн салбарт Хойд Америкийн зах зээл тэр дундаа АНУ финтекийн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт, инновацыг дэмжсэн бодлогын орчны нөлөөгөөр тэргүүлдэг

байсан бол ирээдүйд тус салбарт Ази, Номхон далайн бүс нутаг тэр дундаа Зүүн өмнөд Азийн улсууд, Энэтхэг, Хятад улсуудын зах зээл тэргүүлэх хүлээлттэй байна. “Бостон Консалтинг Групп”-ийн тооцооллоор 2030 он гэхэд нийт финтекийн салбарын жилийн орлого 1.5 их наяд ам.доллар хүрэх бөгөөд үүний 42 хувийг Ази, номхон далайн бүс нутаг дангаар бүрдүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

Зураг. Финтекийн салбарын жилийн орлого, өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Бостон консалтинг групп


Финтекийн хөгжлийн дийлэнх үе нь төлбөрийн систем, төлбөр тооцооны үйлчилгээний хувьслаар тодорхойлогдож ирсэн. 2021 онд л гэхэд нийт финтекийн салбарын орлогын 40 хувь нь төлбөр, тооцооны үйл ажиллагаанаас орж ирсэн бол цаашид ч төлбөр, тооцооны салбар финтекийн салбарт тэргүүлэх байраа хадгалах хүлээлттэй байна. Мөн технологид суурилсан зээл, даатгалын үйлчилгээний салбар 2030 он хүртэл финтекийн салбарын дараагийн голлох тоглогчид байна хэмээн судлаачид үзэж байна.

Түүнчлэн B2B2X бизнес загвар финтекийн салбарын хөгжлийн чиг хандлагыг ирэх жилүүдэд тодорхойлох бөгөөд B2B2X шийдэл нь санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг

дэмжих, хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ үр ашигтай хүргэх боломжийг нь олгох зорилготой. B2B2X үйлчилгээний зах зээлийн жилийн өсөлт 25 орчим хувьтай байхаар хүлээгдэж буй бөгөөд 2030 он гэхэд тус үйлчилгээний жилийн орлого 440 ам.долларт хүрнэ гэсэн тооцоолол гарсан.

Угсармал санхүүгийн үйлчилгээ (Embedded Finance) нь B2B2X үйлчилгээний нэг хэлбэр бөгөөд санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн хэрэгслийг санхүүгийн бус байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээнд шигтгэсэн үйлчилгээ юм. Сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж буй одоо аваад дараа төл үйлчилгээ нь угсармал санхүүгийн үйлчилгээний нэг жишээ юм.

Зураг. Санхүүгийн салбарт тэргүүлэх бизнес салбаруудын орлого, өсөлтийн таамаглал



B2B бизнесийн зах зээлд мөн өсөлтийн өндөр боломж бий. Дэлхийн эдийн засгийн форумын гаргасан судалгаагаар жижиг дунд, үйлдвэрлэлийн зах зээл нь дэлхийн нийт ДНБ, ажил эрхлэлтийн 70 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд дэлхий даяар нийт 400 сая гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулдаг. B2B бизнес загвар тэр дундаа B2B төлбөр тооцоо, зээлийн үйлчилгээ нь жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийг шийдэх хамгийн оновчтой шийдлүүдийн нэгт тооцогдож буй бөгөөд 2030 он гэхэд B2B финтекийн салбар жилийн 32 хувийн өсөлттэйгөөр 285 тэрбум ам.долларын зах зээлийг эзлэх тооцоолол гарсан.

Финтекийн салбарын ирээдүйг тодорхойлох дараагийн нэгэн хандлага нь нээлттэй санхүү (open financing) юм. Нээлттэй санхүү нь хэрэглэгчдийн мэдээлэл санхүүгийн байгууллагууд дунд нээлттэй ашиглагдсанаар хэрэглэгчид өөрсдийн хэрэгцээ, шаардлага, эрсдэлд тохирсон төрөл бүрийн санхүүгийн бүтээгдэхүүнийг нэг дороос авах боломжийг олгох юм. Мөн нээлттэй санхүүгийн цаашдын ирээдүйд санхүүгийн байгууллагууд хэрэглэгчдийн зөвхөн санхүүгийн мэдээллээс гадна эрүүл мэнд, боловсрол болон бусад төрлийн төрд хадгалагдаж буй мэдээлэлтэй холбосноор хэрэглэгчдийн эрсдэл болон санхүүгийн чадавхыг илүү нарийн үнэлэн бүтээгдэхүүнээ санал болгоно.


Инновацийн хабын хөгжил олон улсад

Дэлхий даяар санхүүгийн зохицуулагч байгууллагууд, салбарын бодлого гаргагчид финтекийн хөгжлийг дэмжих, санхүүгийн салбар дахь инновацыг хурдасгах зорилгоор инновацын хурдасгуур бодлогын хэрэгслүүдийг эрчимтэй нэвтрүүлж байна. Тухайлбал 2023 оны 2 дугаар улирлын байдлаар дэлхийн 95 улс санхүүгийн салбар дахь инновацын хурдасгууруудын нэг болох сэндбокс зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Технологийн хөгжил эрчимжихийн хэрээр эдгээр технологийн дэвшлийг боломжит хэмжээнд нь үр ашигтайгаар ашиглах, үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлон, зах зээлийн тогтвортой байдлыг хангах чиглэлийн судалгаанууд тасралтгүй хийгдсээр байгаа бөгөөд эдгээр судалгаанууд нь инновацын хаб болон сэндбокс зохицуулалтыг хамгийн үр дүнтэй, түгээмэл инновацын хурдасгуураар нэрлэж байна. Түүнчлэн сэндбокс

зохицуулалт эсхүл инновацын хаб нь дан дангаар төдийлөн үр ашигтай ажиллахгүй байх талтай тул зохицуулах байгууллагууд сэндбоксыг бүрдэл хэсгээ болгосон инновацын хабыг байгуулах нь зүйтэй гэсэн судалгааны үр дүнгүүд ч гарч байна (Buckley, Arner, and Veidt, 2020).

Сэндбоксын зохицуулалт нь олон улс орнуудад тархан финтекийн эко системд ашиглагдаж буй түгээмэл хэрэгсэл болж буй ч инновац хөгжүүлэгчид, санхүү, технологийн компаниудад сэндбоксод оролцохоос гадна санхүүгийн зах зээлийн зохицуулалтын орчин, мөрдөх стандартуудтай холбоотой зөвлөгөө, заавар авах, салбарыг хөгжүүлэх чиглэлд нягт хамтран ажиллах бодлогын хэрэгсэл дутагдаж буйг мөн онцлох болсон. Инновацын хаб нь уг асуудлыг шийдвэрлэхэд туслах эхлэлийн цэг болж байна гэж зарим судлаачид, бодлого гаргагчид үзэж байна.

Зураг. Инновацын хаб болон сэндбоксын тархалт




Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, Кэмбриджийн уламжлалт бус санхүүжилтийн төвийн

ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТЫН ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Хэрэгцээ, шаардлага

Манай улсын хувьд зах зээлийн эдийн засагт шилжээд гуч гаруй жилийг үзэж буй бөгөөд санхүүгийн зах зээлийн хөгжил саяхныг хүртэл банкны системд төвлөрсөн хөгжлийн хувьд удаашралтай байсан. Харин сүүлийн жилүүдэд хурдтай тохиож буй финтекийн хувьсгал санхүүгийн салбарын өсөлт, хөгжилд эергээр нөлөөлж буй бөгөөд иргэд, олон нийт банкны үйлчилгээнээс гадна олон төрлийн санхүүгийн үйлчилгээг амар, хялбараар шийдэх боломж бүрдэж

байна. Гэсэн хэдий ч хөгжиж буй улс орнуудад байдаг иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролын түвшин, дэд бүтэц, хууль эрх зүйн орчны суурь сул зэрэг асуудлууд өнөөг хүртэл салбарын хөгжлийн гол гацаа болсоор байна. Эдгээр асуудлуудыг технологийн дэвшлийг ашиглан шийдэх, ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд инновацын хаб нь бодлогын чухал хэрэгсэл болно.



Инновацын хаб байгуулах хэрэгцээ, шаардлага:

- ◆ Эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих.
- ◆ Санхүүгийн олон төрөлт үйлчилгээтэй, ухаалаг санхүүгийн төв болох.
- ◆ Санхүүгийн хэрэглэгчдийн эрүүл мэнд, санхүүжилтийн өндөр өртөг.
- ◆ Дижитал санхүүгийн боловсрол.
- ◆ Финтекийн сургалт, судалгааны төвийн үүргийг гүйцэтгэх.
- ◆ Регтек болон суптекийн хөгжүүлэлт.
- ◆ Хамтын ажиллагааны платформ.

Давуу болон сул тал

Финтек инновацын хаб нь санхүүгийн технологийн хөгжлийг дэмжихийн сацуу комплаенсыг нь хангуулж, зохицуулалтын орчныг нь давхар хөгжүүлж байдгаараа гол давуу талыг үүсгэдэг. Финтек инновацын хабын давуу болон сул талыг дор харууллаа.

Давуу тал:

- ◆ Инновацыг дэмжинэ: инновацын хаб, сэндбокс зохицуулалт нь санхүү, технологийн компаниудад хууль, эрх зүйн орчны эрсдэлээс айлгүйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх боломжийг олгодог;
- ◆ Зохицуулалтын орчны тодорхой бус байдлыг бууруулна;
- ◆ Шинэ төрлийн үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлэх үйл явцыг хурдасгана;
- ◆ Хамтын ажиллагааг бэхжүүлэн, илүү үр ашигтай зах зээлийг үүсгэнэ;
- ◆ Хэрэглэгчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаална: инновацын хабын оролцогчид нь тодорхой шаардлага, стандартыг дагаж мөрддөг учир шинэ тутам үүсэж буй эрсдэлээс хэрэглэгчийг хамгаална;
- ◆ Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, хөрөнгө оруулалтыг татна.

Сул тал:

- ◆ Инновацын хабыг ажиллуулах нь хүний нөөц их шаарддаг бөгөөд чадварлаг мэргэжилтнүүдийг татаж ажиллуулах нь хүний нөөцийн зардлыг өсгөдөг;
- ◆ Инновацын хаб нь олон төрлийн оролцогчдын хамтын ажиллагааны талбар болдог учраас тэдгээрийн харилцааг зохицуулахад ихээхэн хүчин чармайлт шаарддаг;
- ◆ Өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах нь инновацын хаб болон оролцогч бүхий л талуудын хувьд хамгийн томоохон сорилт болж буй;
- ◆ Уламжлалт санхүүгийн байгууллагууд болон финтекийн компаниуд хоорондын ашиг сонирхлыг тэнцүүлэх сорилт тулгардаг;
- ◆ Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаа ихээхэн шаардагддаг.

ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТЫН ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ САНАЛ

Үндсэн зорилго, зорилт


Инновацийн хаб нь санхүүгийн зах зээлийн оролцогчид, бизнес эрхлэгчид, гарааны компаниудыг финтекийн салбарт нэвтрэх, хамтран ажиллах, суралцах, инновацыг нэвтрүүлэхэд туслах платформ юм.

Финтекийн инновацын хабын гол зорилго нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах, бүс нутагтаа тэргүүлэх финтекийн зах зээлийг хөгжүүлэхэд бодлого, зохицуулалтын туслалцаа үзүүлэх, шинэлэг санаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ турших боломжийг олгох, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн систем дэх өгөгдлийн санг хөгжүүлэх, финтек салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, судалгаа, шинжилгээг нэмэгдүүлэх, олон нийтийн дижитал санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх үндсэн зорилготойгоор ажиллана.

Үндсэн бүрэлдэхүүн

Манай улсад үйл ажиллагаа явуулдаг бусад төрлийн инновацын хаб, гарааны бизнесүүдэд зориулсан хурдасгуур хөтөлбөрүүдээс ялгаатай нь финтек инновацын хаб нь зөвхөн санхүүгийн салбар дахь технологи, инновацид чиглэснээс гадна санхүүгийн салбарын зохицуулалт, хяналтын орчныг цаг үеийн өөрчлөлтөд нийцүүлэх, оролцогч байгууллагуудын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон бодлого, зохицуулалтын орчны зөвлөгөөг өгөх мөн зохицуулалт, хяналтын технологи регтек, суптекийг хөгжүүлэхэд чиглэж ажиллах болно.

Зураг. Инновацын хабын бүрэлдэхүүн /санал/



Инновацийн хабын үйл ажиллагаа нь дараах чиглэлд хамаарна:

- ◆ Шинэ технологи, инновацыг хөгжүүлэгч санхүү, технологийн компаниудад бодлого, зохицуулалтын орчинтой холбоотой зөвлөгөө, мэдээллийг өгөх;
- ◆ Сэндбоксын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- ◆ Суптекийн хөгжүүлэлт;
- ◆ Санхүүгийн системийн нэгдсэн тоон өгөгдлийн сангийн хөгжүүлэлт;
- ◆ Санхүүгийн технологийн судалгаа, шинжилгээг гүйцэтгэх, шинэлэг санаа, инновацын уралдаан зохион байгуулах;
- ◆ Салбарын оролцогчдыг чадавхжуулах, боловсон хүчний сургалтууд болон хэрэглэгчдийн дижитал санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулах;
- ◆ Гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, “Дэлхийн санхүүгийн инновацын сүлжээ”, “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг”, “Азийн хөгжлийн банк” болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж салбарын хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- ◆ Финтек компаниудыг хөрөнгө оруулагчтай холбох арга хэмжээнүүдийг зохион байгуулах;
- ◆ Ногоон финтекийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулах.

ЭХ СУРВАЛЖ

- ◆ Bar Lev, Maha, and Topliceanu. 2022. Financial frauds' victim profiles in developing countries. *Frontiers in Psychology*.
- ◆ Bank of Mongolia, “Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа”, 2022
- ◆ Buckley, W.Arner, and Veidt. 2020. Building FinTech Ecosystems: Regulatory Sandboxes, Innovation Hubs and Beyond. *Washington University Journal of Law and Policy*, Vol.61.
- ◆ Batchimeg Batbold, “People–Centered Policy Research for the FLPMI Fellowship”, 2023
- ◆ National Research and Consulting Center (NRCC), “Санхүүгийн хэрэглэгчийн итгэлийг тандах судалгаа”, 2019
- ◆ National Statistical Office, available from <https://www.nso.mn/mn>
- ◆ “Залилагчид боломж бүү олго”, 2022 (accessed May 18, 2023); available from <https://police.gov.mn/a/5888>
- ◆ “Бэлтэс мөрөнгийн хохирлын хэмжээ 250 тэрбум төгрөг давжээ”, 2022 (accessed May 18, 2023); available from <https://itoim.mn/article/pekFL/34925>

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ЯПОН УЛС ОУВС–ГИЙН ХОЁР ДАХЬ ТОМ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ХЭВЭЭР БАЙНА.



ВАШИНГТОН, /Kyodo/. Олон улсын валютын сангийн (ОУВС) Гүйцэтгэх зөвлөлөөс гишүүн улс тус бүрийн квотыг одоогийн хувьцаа эзэмшлийн харьцааг өөрчлөхгүйгээр 50 хувиар нэмэгдүүлэх саналыг 2023 оны 11 дүгээр сарын 07–ны өдөр дэмжжээ.

Ингэснээр Япон улс ОУВС–ийн хоёр дахь том хувьцаа эзэмшигчийн байр сууриа хэвээр хадгалж байна.

ОУВС–д оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг гишүүн улс тус бүрийн эдийн засгийн цар хэмжээгээр тогтоовол Хятад улс Японыг гүйцэж түрүүлнэ гэж Японы албаны хүмүүс болгоомжилж байсан юм. ОУВС–ийн гишүүн орнуудын эзэмшиж буй хувьцааны хэмжээ нь тухайн гишүүн улсын саналын эрхтэй холбоотой байдаг.

Японы Сангийн сайд Сүзүки Шүничи хэлэхдээ, ОУВС–гийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувьцааны харьцааг хэвээр хадгалах нь цорын ганц бодит хувилбар гэдгийг онцолжээ. Энэхүү саналыг тус байгууллагын Удирдах зөвлөлийн (Board of Governors) санал хураалтаар 85–аас доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд албан ёсоор батлах бөгөөд ОУВС–аас 12 дугаар сарын 15–ны өдөр квотыг шинэчлэх журмыг батлахаар төлөвлөж байна.

Одоогоор ОУВС–гийн хамгийн том хувьцаа эзэмшигч нь АНУ бөгөөд нийт хувьцааны 17.4 хувь, түүний дараа Япон 6.5 хувь, Хятад 6.4 хувийг тус тус эзэмшиж байна.

ОУВС квотоо голдуу таван жил тутамд шинэчилдэг. Вашингтонд

төвтэй тус сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх төлөвлөгөө нь цар тахал болон бусад хүндрэлийн улмаас мөнгөний хомсдолд ороод буй шинээр гарч ирж буй чинээлэг болон хөгжиж буй орнуудад туслах зорилготой юм.

Үүнээс өмнө ОУВС–гийн хөрөнгийг нэмэгдүүлэх асуудлыг АНУ–ын Конгресс батлах гэж олон жил болсны эцэст 2016 онд хэрэгжиж эхэлсэн юм.

Дэлхийн 190 улс орны гишүүнчлэлтэй ОУВС–гийн Гүйцэтгэх зөвлөл 2025 оны зургаадугаар сар гэхэд эдийн засгийн хүчин чадлын өөрчлөлтийг харгалзсаны үндсэн дээр квотын шинэ хувилбарыг боловсруулахаар ажиллаж эхлэх ёстой.

Хятад болон бусад хурдацтай хөгжиж буй орнуудын зүгээс квотын харьцаа нь гишүүн орнуудын эдийн засгийн цар хүрээг тусгах ёстой гэж шаардаж байгаа юм.

Эх сурвалж: www.montsame.mn

ГАЗРЫН ТОСНЫ ҮНЭ ЦААШИД ГУРВАН ДОЛОО ХОНОГ ДАРААЛАН УНАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.




СИНГАПУР, /Reuters/. Газрын тосны үнэ 2023 оны аравдугаар сарын аравны өдөр бага зэрэг өссөн боловч гурав дахь долоо хоногтоо дараалан унах төлөвтэй байна.

Тодруулбал, Brent маркийн газрын тосны 2024 оны нэгдүгээр сард нийлүүлэх фьючерс хэлцлийн үнэ нэг торх нь 80.01 ам.доллар, АНУ–ын WTI маркийн газрын тосны энэ оны 12 дугаар сард нийлүүлэх үнэ 75.67 ам.доллар болж тус тус буурсан байна.

Ингэснээр энэ долоо хоногт Brent-ийн фьючерс хэлцлийн үнэ өнгөрсөн долоо хоногийнхоос 5.7 хувиар, WTI 5.9 хувиар буурлаа. Ийнхүү гурван долоо хоног дараалан буурсан нь энэ оны дөрөвдүгээр сарын дунд үеэс тавдугаар сарын эхэн үе хүртэл дөрвөн долоо хоног үргэлжилсэн үнийн уналтаас хойших хамгийн удаан үргэлжилсэн бууралт болж байна.

Эх сурвалж: www.montsame.mn

ЯПОН УЛС ХАГАС ДАМЖУУЛАГЧИЙН САЛБАРТ ИХ ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛНА.



JAPAN TO ALLOCATE 1.9 TRIL. YEN TO DOMESTIC CHIP PRODUCTION

ТОКИО, /NNK/. Японы Засгийн газар хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 1.9 орчим их наяд иен буюу ойролцоогоор 12.6 тэрбум ам.доллар зарцуулахаар төлөвлөж байна.

Үүнээс 5 тэрбум орчим ам.долларыг дэвшилтэт хагас дамжуулагчийг бөөнөөр үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хуваарилна. Энэ нь Күмамото мужид Японд хоёр дахь үйлдвэрээ барих талаар судалж буй Тайванийн TSMC компанид дэмжлэг болно гэж үзэж байна. Мөн Японд дэвшилтэт хагас дамжуулагч үйлдвэрлэхээр төлөвлөж буй "Rapidus" зэрэг компаниудыг дэмжихэд 4.2 тэрбум ам.доллар зарцуулж магадгүй байна.

Түүнчлэн хагас дамжуулагчийн тогтвортой нийлүүлэлтийг дэмжихэд 3.8 тэрбум орчим ам.долларыг зарцуулах ажээ.

Эх сурвалж: www.montsame.mn

ДАРСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ СҮҮЛИЙН 62 ЖИЛИЙН ХАМГИЙН ДООД ХЭМЖЭЭНД ХҮРТЭЛ БУУРНА.

Энэ онд дэлхийн дарсны үйлдвэрлэл өнгөрсөн оныхоос 7 орчим хувиар буурах төлөвтэй байна гэж Олон улсын усан үзмийн мод, дарсны байгууллага (OIV) мэдэгджээ. Энэ нь 1961 оноос хойших хамгийн доогуур үзүүлэлт юм.

Тус байгууллага дэлхийн нийт дарсны 94 хувийг үйлдвэрлэдэг улс орнуудын мэдээлэлд үндэслэн дээрх таамгийг гаргасан байна. Үйлдвэрлэл буурсан нь цочир хүйтрэл, хүчтэй аадар бороо, ган гачиг зэрэг цаг агаарын таагүй үзэгдлүүдтэй холбоотой ажээ.



“Дэлхийн бөмбөрцгийн хойд болон өмнөд хагасыг хамарсан цаг агаарын гамшиг ийм нөхцөл байдалд хүргэсэн” гэж OIV-ийн Статистикийн албаны дарга Жоржио Делгроссо ярилаа.

2022 онд үйлдвэрлэл 12 хувиар өссөн дүнтэй байсан АНУ-ын хувьд байдал илүү хүнд байна.

Дэлхийн хэмжээнд үйлдвэрлэл буурах нь салбарт муугаар нөлөөлөх боловч дэлхий даяар эрэлт багасаж байгаа тул нийт зах зээл харьцангуй тэнцвэртэй байж, үнэ унахгүй байх магадлалтай.

“Хятадын эдийн засгийн өсөлт 2018 оноос хойш удааширч байгаа тул дарсны хэрэглээ, импорт илт буурч байна. Үйлдвэрлэл хумигдаж байгаа нь сайн мэдээ биш ч гэсэн хэрэглээ буурах нь үнийг тэнцвэржүүлэхэд нөлөөлнө” гэж ноён Ж.Делгроссо хэллээ.

Ташрамд дурдахад, эрэлт буурснаас үүдэлтэй дарсны илүүдэл нөөцийг устгахад 200 сая евро зарцуулна гэж Францын засгийн газар өнгөрсөн наймдугаар сард мэдэгдэж байв.


Эх сурвалж: www.bloomberg.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 11 дугаар сарын 20-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,547.38 +33.36 (+0.74%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


33,338.29 -49.74 (-0.15%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,496.36 -7.89 (-0.11%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

14,284.53 +159.53 (+1.13%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн Зохицуулах Хороо



@FRC_of_Mongolia